# “БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ ШИНЭЧЛЭН, ЗУРАГЛАЛ ХИЙХ” АЖЛЫН ТАЙЛАН

| | |
|---|---|
| Захиалагч: | БОАЖЯ - Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар |
| Санхүүжүүлэгч: | Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн (KfW) банк<br>“Биологийн олон янз байдлын хамгаалал ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төсөл |
| Гүйцэтгэгч: | Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтэс |

## Тайлан боловсруулсан:

- УЦУОСМХ-ийн Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтсийн дарга ............................ /Г.Батхишиг/

- Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтсийн Ерөнхий инженер, Багийн ахлагч ........................... /З.Нарангэрэл/

- Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтсийн Мэдээллийн сангийн Захирагч .......................... /Б.Ундрах/

# ГАРЧИГ

Гүйцэтгэсэн ажлын хураангуй ..... 4
Оршил ..... 9
Байгаль орчны мэдээллийн сан ..... 11
Захиалгат ажлын танилцуулга ..... 15
Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил ..... 18
Багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь ба гүйцэтгэсэн ажил ..... 19
Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан шинээр хөгжүүлэх ..... 22
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх ..... 28
Мэдээллийн санг  шинэчлэн хөгжүүлж мэдээллээр баяжуулах ..... 34
Байгалийн ургамлын мэдээллийн сан ..... 34
Амьтны мэдээллийн сан ..... 46
Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээллийн санг шинэчлэх ..... 50
Төслийн хүрээнд хийсэн судалгааны мэдээг мэдээллийн санд оруулах ..... 55

## Гүйцэтгэсэн ажлын хураангуй

| **Үйл ажиллагааны нэр** | **Мэдээллийн сангийн нэр** | **Хийж гүйцэтгэсэн ажил ба Үр дүн** |
|---|---|---|
| Мэдээллийн санг шинээр хөгжүүлэх ажил | Байгаль орчны нөлөөлийн нэгдсэн сан шинээр хөгжүүлэх | - Байгаль орчны мэдээллийн сан дах тусдаа салангид байгаа олон төрлийн мэдээллийн дэд сангуудыг уялдуулан холбож газарзүйн болон тоон мэдээллийг нэгдсэн нэг порталаар нэгтгэн харуулах боломжийг бүрдүүлж “Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан” - г шинээр үүсгэв.<br>- Шинээр хөгжүүлсэн мэдээллийн санд хамруулсан дэд сангууд;<br>  - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ https://eic.mn/eia/<br>  - Байгаль орчны аудит https://eic.mn/audit/<br>  - Байгаль орчны менежментийн төлөвлөгөө https://eic.mn/envmng/<br>  - Эвдэрсэн газар https://eic.mn/dlid/<br>  - Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагаа https://eic.mn/cadastre/<br>- Мэдээллийн сангуудаас өгөгдөл мэдээллийг ямар ямар үзүүлэлтээр нэгтгэх талаар дүн шинжилгээ хийсэн.<br>- Мэдээллийг нэгтгэн харуулах ижил төстэй портал, мэдээллийн сайт, бусад холбогдох материалуудыг судалж танилцсан.<br>- Мэдээллийн нэгдсэн порталын загварыг (template) судалж сонгон интерфейсийг монгол хэл рүү хөрвүүлсэн.<br>- Мэдээллийн нэгдсэн порталын олон нийтийн хэсэг нүүр хуудас хэсгийн интерфейсийн загварыг гаргаж программ хөгжүүлэлтийг хийсэн.<br>- Нүүр хуудасны хэсэгт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Эвдэрсэн газар, Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагааны сангаас мэдээ авч нэгтгэн тоон ба Зурган мэдээ харуулах хэсгийн загварыг гаргаж программ хөгжүүлэлтийг хийсэн.<br>- Байгалийн ургамал, Амьтны мэдээллийн сангаас Улаан ном, Улаан дансны тоон мэдээллийг нэгтгэн харуулах талбар үүсгэж программ хөгжүүлэлтийг хийсэн.<br>- Статистик тайлангийн хэсэгт БОХ мэдээллийн сангаас Биологийн олон янз байдлын мэдээг хүснэгт ба графикаар харуулах программ хөгжүүлэлтийг хийсэн.<br>- Мэдээ харуулах хэсгийн Төслийн мэдээлэл хэсгийн загварыг гаргаж программ хөгжүүлэлтийг хийсэн.<br>- Мэдээллийн санд хавсаргасан *pdf файлыг шууд нээж харуулах боломжийг бүрдүүлж программчилсан.<br>- Мэдээллийн сангийн олон нийтэд зориулсан хэсэг болон Газарзүйн мэдээний хэсгийг англи хэл рүү хөрвүүлсэн. |

| | | |
|---|---|---|
| | | - Газарзүйн мэдээг GeoMoose 3.10.1 хувилбараар харуулах программ хөгжүүлэлт хийсэн.<br>- Мэдээллийн сангуудаас мэдээг нэг порталаар нэгтгэн харуулах программ хангамжийг PHP ашиглан хөгжүүлж кодчилсон.<br>- Байгаль орчны мэдээллийн сангийн программ хөгжүүлэлтэд ахиц дэвшил гарч нэг цонхоор олон мэдээг нэгтгэн харуулах боломжийг бүрдүүлж программчлах шийдлээ олсон нь чухал ач холбогдолтой ажил болсон.<br>Мэдээллийн нэгдсан санг серверт байршуулан шалгалт, тохируулга хийж засварласан. |
| Мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх, мэдээллээр баяжуулах<br>(агуулга бүтцийг сайжруулж, программ хангамжид нэмэлт өөрчлөлт оруулах, мэдээллээр баяжуулах мэдээг шинэчлэх) | - Байгаль орчны үнэлгээний мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх | - Мэдээллийн сангийн олон нийтийн хэсэг болон мэдээ оруулах хэсгийн хэлбэржүүлэлтийн Framework болох Bootstrap v3.3.5 хувилбарыг Bootstrap v4.3.1 хувилбарт шилжүүлсэн. Уг шинэчлэлтийн хүрээнд олон нийтийн хэсэг нүүр хуудас болон мэдээ харуулах хэсгийн хэрэглэгчийн интерфейс (template) бүрэн солигдсон бөгөөд олон нийтэд нээлттэй харуулах 5 хүснэгтийн загвар, кодыг шинэчилсэн.<br>- Мэдээний хүснэгтүүдэд “хуулах, excel, pdf файлд мэдээг гаргах, хэвлэх” функцүүдийг нэмсэн. Олон нийтийн бүх хэсгийг англи, монгол хэл дээр орчуулсан.<br>- Мэдээллийн сангийн Газарзүйн мэдээг дүрслэх Framework-ийг GeoMoose 3.8.0 -аас 3.10.1 хувилбар луу шилжүүлсэн. Мөн (.*map, *.xml, .*html, *.js) өргөтгөл бүхий файлуудыг англи монгол хэл дээр хөрвүүлсэн.<br>- Мэдээллийн сангийн мэдээ оруулах хэсгийн шинэчлэлтийн хүрээнд удирдах хуудас болон мэдээ хүснэгтүүдийн интерфейс (template) бүрэн солигдсон бөгөөд 13 хүснэгтийн загвар, кодыг шинэчлэсэн. Мөн тухайн хүснэгтүүдэд “хуулах, excel, pdf файлд мэдээг гаргах, хэвлэх” функцүүдийг нэмсэн. Тухайн хүснэгтүүдийн мэдээг тодорхой утгаар хайлт хийн эксел болон shape файлаар гаргах функцүүдийг нэмсэн.<br>- 6 лавлах хүснэгтэд англи нэршил оруулах багана нэмж англи нэршлүүдийг мэдээллийн санд нэмж оруулсан. “Мэргэжлийн байгууллагын эрхийн бүртгэлд; Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага; Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх нь дууссан бүхий мэргэжлийн байгууллага;” хүснэгтүүдэд регистрийн дугаараар хайх хайлтыг нэмсэн. Мөн батлагдсан БОННҮ-ний тайлангийн хүснэгтээс тайлангийн кадастрын зураг болон тайлангийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээний мэдээлэл-ийг шууд оруулах хэсгийг шинээр нэмсэн.<br>- Англи хэлний орчуулгыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн орчуулгын хэсгээс хянаж байна. |

| | | |
|---|---|---|
| | | - Мэдээллийн нэгдсан санг серверт байршуулан шалгалт, тохируулга хийж засварласан. |
| | - Байгалийн ургамлын мэдээллийн сан | - Мэдээллийн санг англи, монгол хэлний сонголттой болгож программыг хөгжүүлсэн. Language.php – англи, монгол хэлээр бэлтгэсэн.<br>- Нүүр хуудасны 13 хүснэгтийг шинэчилж, 135 php файл дээр программ хөгжүүлэлт хийсэн.<br>- Судалгааны өгүүлэл оруулах шинэ хүснэгт үүсгэж программ хангамжийг хөгжүүлж мэдээллийн санд нэмж оруулсан.<br>- Ангилалзүй дээр англи хэлээр хайлт хийх программ бичсэн.<br>- Газарзүйн мэдээнд УТХГН-ийн мэдээллийн сангийн ерөнхий мэдээллийг холбох view үүсгэн программ хөгжүүлсэн.<br>- Улаан ном, Улаан данс мэдээллийг нүүр хуудас дээр харагдахаар программ хөгжүүлэлт хийсэн.<br>- Мэдээллийн сангийн Газарзүйн мэдээг GeoMoose3.0 хувилбарт шилжүүлж газарзүйн мэдээний давхарга үүсгэх файлууд (mapinfo file, *map, *mapbook.xml, language_mn, language_en) бэлтгэж программ хөгжүүлэлт хийж шинэчилсэн.<br>- Монгол орны ургамлын зүйлийн жагсаалт 2022 онд шинэчлэгдсэн тул байгалийн гуурст дээд ургамлын зүйлийн 3041 мэдээг шүүж ургамлын ерөнхий мэдээллийг шинэчилж, англи мэдээллийг нэмж оруулсан.<br>- Өмнөх судалгааны гербараас зүйл тус бүрийн цэгэн мэдээллийн координатыг түүж Газарзүйн мэдээллийн системийн ArcGIS программ дээр оруулж нэг адил хэмжээ, форматаар зургийн эхийг бэлтгэсэн.<br>- Мэдээллийн сан дах ургамлын зүйлийн мэдээллийг бүрэн шинэчлэхийн тулд жишиг болгон гуурст дээд ургамлын 100 зүйлийн ургамлын мэдээг бүрэн шинэчлэн оруулсан.<br>- Судалгааны өгүүлэл хүснэгтэд 27 өгүүллийн мэдээ оруулж файлыг хавсаргасан.<br>- Ургамлын судалгааны тайланд “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд 2015-2020 онд хийсэн Бэлчээрийн тогтвортой менежментийн суурь мэдээлэл бүрдүүлэх судалгааны 15 тайланг оруулсан. |
| | - Амьтны мэдээллийн сан | - Мэдээллийн сангийн лавлах хүснэгтүүдэд англи талбар нэмж хэлний орчуулга хийсэн.<br>- Мэдээллийн санг англи, монгол хэлний сонголттой болгож программыг хөгжүүлсэн. Language.php – англи, монгол хэлээр бэлтгэсэн.<br>- Судалгааны тайлангийн хүснэгтэд шинээр 2 талбар нэмсэнтэй холбоотой код бичих ажил хийсэн.<br>- Судалгааны өгүүлэл оруулах шинэ хүснэгт үүсгэж программ хангамжийг хөгжүүлж мэдээллийн санд нэмж оруулсан. |

| | | |
|---|---|---|
| | | - Ангилалзүй дээр англи хэлээр хайлт хийх программ бичсэн.<br>- Орчуулгын файл бэлдэж Зөвлөхөөр хянуулж засвар хийсэн.<br>- Мэдээллийн санд шинээр бүлэг болон хэрэглэгчийн эрх үүсгэж өгсөн.<br>- Мэдээллийн сангийн Статистик тайлангийн хэсэгт нэмэлт хөгжүүлэлт хийж амьтны ангилал зүйгээр, Улаан данс, Улаан ном болон амьтны ховордлын зэргээр мэдээг нэгтгэн Зүйлийн тоогоор гаргаж үр дүнг хүснэгт болон графикаар харуулах боломжийг бүрдүүлж программ хөгжүүлэлт хийсэн.<br>- Амьтны ерөнхий мэдээлэл, төлөв байдал дээр Улаан данс, Улаан номны мэдээллийг холбож харуулах кодыг хөгжүүлж мэдээллийг тухайн зүйлийн амьтан бүр дээр харуулах боломжийг бүрдүүлсэн.<br>- Газарзүйн мэдээний давхаргад Ан амьтны байршлыг зүйл тус бүрээр харуулах давхаргыг оруулан зурагласан байна. Мөн тодорхой зүйл амьтны Агнуурын бүсийн зургийн давхарга оруулсан.<br>- Амьтны Улаан дансны 216 мэдээ, Улаан номны 109 мэдээ болон тархацын зургийг шинэчлэн оруулсан.<br>- Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн хүрээнд 2015-2020 онд хийсэн ан амьтны судалгаа, менежментийн төлөвлөгөөний 6 мэдээг Амьтны судалгааны тайланд оруулан. |
| | - Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээллийн сан | - Холбогдох хууль эрх зүйн баримт бичигтэй танилцсан<br>- Хуучин мэдээллийн сангийн агуулга бүтцийг судалж шинэчлэн хөгжүүлэх мэдээллийн сангийн бүтцийг тодорхойлсон<br>- Мэдээллийн санд оруулах өгөгдлийн хүснэгтийг тодорхойлсон<br>- Хүснэгт бүрийн талбарын нэр, өгөгдлийн төрөл, хязгаарлалт, холбоосыг гаргаж 13 хуудас бүхий Мэдээллийн сангийн тайлбар бичгийг боловсруулсан.<br>- Мэдээллийн сангийн бүтцийг гаргаж Enterprise Architect программ дээр харилцан холбоосыг гаргасан.<br>- Notepad++ дээр 1156 мөр бүхий Өгөгдлийн сангийн бүтэцлэгдсэн загвар SQL (Structured Query Language) бэлтгэсэн.<br>- PgAdmin 4.0 ашиглан өгөгдлийн санг үүсгэсэн.<br>- Мэдээллийн сангийн Газарзүйн мэдээг GeoMoose3.0 хувилбарт шилжүүлж газарзүйн мэдээний давхарга үүсгэх файлууд (mapinfo file, *map, *mapbook.xml, language_mn, language_en) бэлтгэсэн.<br>- Мэдээллийн сангийн Лавлах хүснэгтүүдэд мэдээ оруулсан.<br>- Мэдээллийн сангийн интерфейсийг монгол, англи хэл рүү хөрвүүлэх боломжийг бүрдүүлж программ хөгжүүлсэн.<br>- Газарзүйн мэдээлэлд байгаль орчинд хохирол учруулсан газрын байршлыг харуулах ба хохирол учирсан оноор, хохирлыг төрлөөр харах давхарга үүсгэсэн. |

| | | |
|---|---|---|
| | | - Мэдээллийн сангаас Хохирол учруулсан болон хохирол тооцсон байгууллагын мэдээ, Байгаль орчинд учруулсан хохирлын мэдээ, Хохирол тогтоосон актын мэдээ, Хохирлыг нөхөн төлбөр, нөхөн төлбөр төлсөн болон хохирлыг арилгасан талаарх мэдээг харуулахаар загварчилж программ хөгжүүлэлт хийсэн. |
| Ажлын явцыг хэлэлцэх | - Хамруулсан бүх мэдээллийн сангуудаар | - Төслийн баг 10 сарын 15-аас эхлэн 7 хоног бүрийн Баасан гаригт ажлын явцыг танилцуулж хэлэлцэн санал солилцсон. /Нийт 9 удаа/<br>- 11 сарын 4-нд БОАЖЯ, Төслийн мэргэжилтэн нарт ажлын явцыг танилцуулж хэлэлцүүлэн санал, зөвлөмж авч ажилласан.<br>- Байгалийн ургамал судлаач, Доктор Б.Оюунцэцэг багш, судлаач, Доктор Ш.Баасанмөнх нартай групп чат үүсгэн санал зөвлөгөө авч, мэдээлэл солилцон хамтран ажилласан.<br>- Амьтан судлаач Доктор Б.Лхагвасүрэн багштай уулзаж санал зөвлөгөө авч, мэдээлэл солилцон хамтран ажилласан.<br>- 12 сарын 19-нд БОАЖЯ-ны холбогдох газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн болон төслийн нэгжээс оролцуулсан хуралд танилцуулж хэлэлцүүлсэн. |
| Тайлан боловсруулах | - Эхлэлийн тайлан | - Эхлэлийн тайлан боловсруулж 8 сарын 9- нд БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны удирдлагын газрын мэргэжилтэн Г.Оюунгэрэл, Төслийн мэргэжилтэн М.Амгалан нарт емайлаар явуулсан. |
| | - Эцсийн тайлан | - Төслийн гүйцэтгэлийн тайлан боловсруулж 12 сарын 14-нд Хүрээлэн буй орчны удирдлагын газрын мэргэжилтэн Г.Оюунгэрэл, Төслийн мэргэжилтэн М.Амгалан нарт емайлаар явуулсан. |

# Оршил

Биологийн олон янз байдлын тухай конвенцийг Монгол Улсын Их Хурал 1993 онд соёрхон баталснаар Монгол Улс тус конвенцид албан ёсоор нэгдэн орсон дэлхийн 30 дах орон болсон юм. Конвенцид манай улс нэгдэн орсноор биологийн олон янз байдлыг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, генетик нөөцийн ашиглалтаас олох ашгийг шударга, тэгш, хүртээмжтэй хуваарилах үндсэн гурван зорилгод чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, олон улс, бүс нутгийн хэмжээнд санаачилгатай хамтран ажиллах, үндэсний бодлого, үр ашигтай зохицуулалтыг хэрэгжүүлэх үүргийг олон улсын өмнө хүлээсэн.

Монгол Улсын Засгийн газар 1996 онд “Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр”-ийг дэмжин хэрэгжүүлсэн. Монгол орны нийгэм, эдийн засаг, байгаль орчинд гарсан эрс өөрчлөлтүүд болон хөтөлбөрийн хэрэгжилтийн явцаас үзэхэд биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн хувьд конвенцийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, байгаль орчны талаар боловсруулан гаргасан төрийн бодлого, шийдвэрийн уялдааг хангасан байдлаар шинэчлэн боловсруулах зорилгоор 2015-2025 онд хэрэгжүүлэх Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн 2015 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 325 дугаар тогтоолоор баталсан.

Монгол улсын биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн эрхэм зорилго нь Монгол Улсын иргэн бүрийн Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг нь баталгаатай болгох нөхцөлийг бүрдүүлэх явдал мөн.

Биологийн олон янз байдал гэдэг нь дэлхий дээрх амьд бие организмын олон янз байдал тухайлбал хуурай газар, далай тэнгис, усан орчны экосистем, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох амьтан, ургамал зэрэг амьд биет болон тэдгээрийн генетикийн олон янз байдлыг багтаасан нийлмэл ойлголт юм.

Биологийн олон янз байдлын хамгийн чухал үнэт зүйл нь хүн төрөлхтөнд юугаар ч орлуулахгүй “экосистемийн үйлчилгээ”-г үзүүлдэгт оршдог. Нэгэнт л экоистемийн үйлчилгээ нь хүний мөнхийн хэрэгцээ учраас түүний үнэ цэнийг бууруулахгүйгээр хамгаалах, зүй зохистойгоор ашиглах замаар хүний хэрэгцээг хангах арга замыг эрэлхийлсэн оновчтой санаачлагууд эцэсдээ байгаль орчны урт, богино хугацааны төлөвлөлт, хууль, дүрэмд тусгалаа олж хэрэгжих учиртай.

Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөрийн Тэргүүлэх чиглэл 1-рт “биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах талаарх шийдвэр гаргагч, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх”-ээр заасан бөгөөд уг тэргүүлэх чиглэлийн хүрээнд тодорхойлсон Зорилго 2-т “Байгаль орчны мэдээллийн сангийн биологийн олон янз байдлын мэдээллийн нэр төрөл, хүртэцийг нэмэгдүүлж, биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглахтай холбоотой шийдвэр гаргахад ашиглах тогтолцоог бүрдүүлэх” талаар тодорхойлсон.

Мэдээллийн санд орж байгаа мэдээллийг нэгтгэн боловсруулах, чанарт хяналт тавих, түгээх чадавхийг сайжруулах, биологийн олон янз байдлын мэдээллийн тогтолцоо бүрэн шинэчлэгдэж сайжирсан байх зэрэг мэдээллийн сантай холбоотой тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэхээр хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтэд бодит мэдээллийг шуурхай түгээх, мэдээллийг хүртээмжтэй байлгах зорилгоор мэдээллийн технологийг ашиглан Биологийн олон янз байдлын мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлж мэдээллээр баяжуулах, мэдээллийг шинэчлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

## Байгаль орчны мэдээллийн сан

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуульд заасны дагуу байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт, цаг агаар, уур амьсгал болон байгаль орчны бохирдол, өөрчлөлтийн төлөв байдал, байгаль орчны эрх зүйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын мэдээллийг Байгаль орчны мэдээллийн сангаар дамжуулж олон нийтэд нээлттэй хүргэдэг. "Байгаль орчны мэдээллийн сан" гэж байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн иж бүрдэл юм.

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуульд 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар “Байгаль орчны мэдээллийн сан” гэсэн Долдугаар бүлгийг нэмж мэдээллийн сангийн хэлбэр, тогтолцоо, бүрдэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах байгууллага, мэдээлэл төвлөрүүлэх байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, мэдээллийн сан бүрдүүлэх ерөнхий шаардлага зэрэг зүйл заалтуудыг оруулан баталсан. Засгийн газрын 2010 оны 85 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны мэдээллийн сангийн эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалт”-ыг баталсан.

Байгаль орчны мэдээллийн санг 2010 оноос эхлэн үе шаттайгаар хөгжүүлж ирсэн ба мэдээллийг дуу авиа, дүрс бичлэг, зураг, график, бичгийн хэлбэрээр хүргэж байгаа бөгөөд мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, түгээх үйл ажиллагаа, техник, технологи нь мэдээлэл, харилцаа холбоо, технологийн төрийн нэгдсэн бодлоготой уялдуулан хөгжүүлсээр байна.

Байгаль орчны мэдээллийн санг хөгжүүлэхэд веб орчны программчлалыг газарзүйн мэдээллийн системтэй хослуулан олон нийтэд нээлттэй байх шаардлага тавигддаг ба нээлттэй эхийн (open source) Веб програмчлалын PHP, Geomoose, GeoNetwork, JQuery, Bootstrap, Highcharts, PHPExcel, PHPSpreadSheet, php-shapefile программ хангамжуудыг ашигладаг.

Өгөгдлийн сангийн удирдлагын систем нь PostgreSQL, PostGIS өргөтгөл ба Газарзүйн мэдээллийн системд зураг боловсруулалтын ArcGIS, QGIS программ хангамж ашиглана.

Mapserver - Оронзайн мэдээг агуулсан вэб хуудас байгуулахад зориулсан эх код нь нээлттэй программ хангамж. Linux/Unix болон Windows дээр ажиллана.

PostgreSQL /PostGIS - Эх код нь нээлттэй өгөгдлийн сангийн удирдлагын систем. Газар зүйн мэдээлэлтэй ажиллах PostGIS гэсэн өргөтгөлтэй.

Байгаль орчны мэдээллийн сангийн үйлдлийн систем нь LinuxOS бол Вэб сервер нь Apache, PHP болон MapScript байна. Мэдээллийн сан нь олон нийтэд зориулсан Нүүр хэсэг (front-end) ба мэдээ оруулах хэрэглэгчдэд зориулсан (back-end) гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ.

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 2012 оны нэмэлт өөрчлөлтийн дагуу улсын хэмжээнд Байгаль орчны мэдээллийн сан нь 23 бүрдэл хэсэгтэй бөгөөд одоогийн байдлаар 42 дэд мэдээллийн санг https://eic.mn цахим хаягаар олон нийтэд нээлттэй түгээж байна.

Байгаль орчны мэдээллийн сан нь газар, түүний хөрс, газрын хэвлий, ашигт малтмал, ой, ус, амьтан, ургамал, агаар, орчны мэдээлэл, уур амьсгал, байгаль орчинд нөлөөлөх байдал, уул уурхайн ашиглалт, эвдэрсэн газар, байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг зөрчил, байгаль орчны статистик тайлан түүний дотор биологийн олон янз байдлын тайлант мэдээ зэрэг үндэсний хэмжээний өргөн хүрээний олон төрлийн мэдээллийг багтаасан цогц бүрдэл юм. Мэдээллийн сан нь мэдээллийн тухай мэдээ буюу Мета мэдээллийг агуулна. Мета мэдээлэлд мэдээний эх сурвалж, мэдээ бүрдүүлсэн он, мэдээний төрөл, хэмжээ, масштаб зэрэг мэдээг агуулна.


БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ
Байгаль орчны мэдээллийн сан
“байгаль орчны мэдээллийн сан” гэж байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн иж бүрдлийг хэлнэ.
Байгаль орчныг хамгаалах хуулиас..
Газар, түүний хөрс
Газрын хэвлий, ашигт малтмал
Ус, рашаан
Ой
Байгалийн ургамал
Амьтан
Агаар, түүний бохирдол
Уур амьсгал
Байгалийн гамшиг
Химийн хорт болон аюултай бодис
Хог хаягдал
Тусгай хамгаалалттай газар нутаг
Байгаль орчны эрх зүй
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
Байгаль орчны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт
Байгаль орчны статистик мэдээлэл, тайлан
Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал
Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөц
Мета мэдээллийн сан
Байгаль орчны талаарх бусад мэдээлэл
Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээлэл
Байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл
Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан
Copyright 2022. Байгаль орчны мэдээллийн төв.
Цаг уур, орчны шинжилгээний газрын байр, Жуулчны гудамж 5,
Улаанбаатар 15160
976 - 11 - 327982
976 - 11 - 329968
support@eic.mn

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 37 дугаар зүйлд Байгаль орчны мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага, хэрэгжүүлэх хугацааг сан тус бүрээр нь тодорхой заасан байдаг.

Байгаль орчны мэдээллийн санг хариуцагч байгууллага нь мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, хадгалах, хамгаалах, шинэчлэх, ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлд бүртгэл хөтлөх, баримтжуулах, мэдээллийн сангийн нөөц хувь бүрдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх асуудлаар мэдээлэл бүрдүүлэх, төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй ажилладаг.

Улсын мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх байгууллага нь улсын мэдээллийн санд цахим хэлбэрээр буюу сүлжээгээр холбогдох мэдээг нийлүүлэх, байгаль орчны өгөгдөл, мэдээллийг шинэчлэх, өөрчлөлт оруулах, шинэ өгөгдөл, мэдээллээр мэдээллийн санг баяжуулах, байгаль орчны өгөгдөл, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцах, байгаль орчны өгөгдөл, мэдээллийн анхдагч боловсруулалтыг хариуцах, улсын мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх техник, технологийн нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээдэг.

## Захиалгат ажлын танилцуулга

БОАЖЯ-ны захиалгаар Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн (УЦУОСМХ) Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтэс “Биологийн олон янз байдлын мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлж зураглал хийх” ажлыг “Биологийн олон янз байдлын хамгаалал ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төслийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэв.

Байгаль орчны мэдээллийн сан дах биологийн олон янз байдлын хамгаалал, байгаль орчны нөлөөлөл, амьтан, ургамалтай холбоотой мэдээллийн дэд сангуудыг уялдуулан холбож Биологийн олон янз байдлын талаарх мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх, хуучин байгаа мэдээллийн сангуудын агуулга бүтцийг сайжруулж, программ хангамжид нэмэлт өөрчлөлт оруулах, мэдээ, мэдээллээр баяжуулахад ажлын зорилго оршино.

“Биологийн олон янз байдлын мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлж зураглал хийх” ажлыг 2022 оны 7 сарын 1-ээс эхлэн 6 сарын хугацаанд байгаль орчны мэдээллийн сангийн мэргэжилтэн, програмчлагч зэрэг 7 хүний бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэв.

Захиалгат ажлыг Байгаль орчны мэдээллийн сангийн хэлтсийн дарга Г.Батхишиг, Ерөнхий инженер З.Нарангэрэл нар удирдан зохион байгуулж мэдээллийн сангийн програмчлагч Б.Ундрах, З.Цэнд, М.Оюунболор болон Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн Н.Гандолжин, Б.Вандардорж нар оролцон ажиллав.

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны удирдлагын газрын Байгалийн нөөц, ургамал хариуцсан мэргэжилтэн Г.Оюунгэрэл, Байгалийн нөөц, амьтан хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхдөш, “Биологийн олон янз байдлын хамгаалал ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” KfW төслийн мэргэжилтэн М.Амгалан нартай байнгын холбоотой ажиллаж харилцан санал солилцон зөвлөгөө авч хамтран ажилласан.

Байгалийн ургамал, Амьтны мэдээллийн санд ангилал зүйн мэдээ оруулах, байгаа мэдээллийг хянаж засварлах, биологийн төрөл зүйлийн ерөнхий мэдээлэл, тархалтын зураг оруулж санал, зөвлөмж авах, мэдээллийн сангийн англи хэлний орчуулгыг хянуулах зорилгоор МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Биологийн тэнхимийн Байгалийн ургамал судлаач, Доктор проф Б.Оюунцэцэг, Амьтан судлаач Доктор, проф Б.Лхагвасүрэн нартай хамтран ажилласан.

Захиалгат ажлыг гүйцэтгэхдээ ажлын даалгаварт заасны дагуу биологийн төрөл зүйлийн талаарх судалгаа, хууль эрхзүйн баримт бичигтэй танилцах, олон улсын ижил төстэй материалыг үзэх, шинээр болон шинэчлэн хөгжүүлэх мэдээллийн сангийн дизайныг гаргах, ашиглах программ хангамжийг сонгож хөгжүүлэх, программ хангамжийг шалгах, серверт суулгах, туршилтаар мэдээ оруулж засвар тохируулга хийх, мэдээ оруулах, захиалагчийн хүсэлт, зөвлөмжийн дагуу шинэчлэлт, сайжруулалт хийх зэрэг шат дараатай ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны мэдээллийн сан дах дэд сангуудыг уялдуулан холбож газарзүйн болон тоон мэдээллийг нэгдсэн нэг цонхоор харуулах боломжийг бүрдүүлж шинээр сан үүсгэх, Байгалийн ургамал, Амьтан, Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр дэд сангуудын агуулга, бүтцийг сайжруулж программ хангамжийг хөгжүүлэх, мэдээ бүрдүүлэх ажлыг сайжруулах ажлууд хийгдсэн. Төслөөр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хамрагдсан мэдээллийн сангууд болон гүйцэтгэсэн ажлуудыг дараах хүснэгтээр харуулав.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа ба хамрагдах мэдээллийн сан

| **Үйл ажиллагааны нэр** | **Хамруулсан дэд сангууд** | **Гүйцэтгэсэн ажил** |
|---|---|---|
| 1. “Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан” шинээр хөгжүүлэх | ▪ Эвдэрсэн газар<br>▪ Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагаа<br>▪ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ<br>▪ Байгаль орчны аудит<br>▪ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | • Мэдээллийн санд шинэчлэл, сайжруулалт хийх талаар судлах, холбогдох хууль эрх зүйн баримт бичиг болон бусад материалтай танилцах<br>• Мэдээллийн сангуудыг нэгтгэн нэг цонхоор харуулах дизайныг судлах ба программм хангамжийг сонгож тогтоох<br>• Мэдээллийн сангийн агуулга, бүтцийг тодорхойлж өгөгдлийн сангийн тайлбар толь бичиг бэлтгэх<br>• Логик загварыг тодорхойлох, SQL код боловсруулах<br>• Шинээр хөгжүүлэх мэдээллийн сангийн мэдээ оруулах хэсгийн (back end), олон нийтийн нүүрэн хэсгийн (front end) программ хангамжийг хөгжүүлэх<br>• Интерфейсийг англи хэл рүү хөрвүүлэх<br>• www.eic.mn -д байршуулах, тогтмол ажиллагааг шалгах, засварлах<br>• Хэрэглэгчийн гарын авлага боловсруулах<br>• Мэдээллийг шинэчлэх, засвар үйлчилгээ хийх, мэдээллээр баяжуулах талаар холбогдох албан хаагч, мэргэжилтнийг талыг сургах |
| **2.** Мэдээллийн сангийн агуулга бүтцийг сайжруулж, программ хангамжид нэмэлт өөрчлөлт оруулан сайжруулж, мэдээ, мэдээллээр баяжуулах | • Байгалийн ургамал<br>• Амьтан<br>• Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр | • Мэдээллийн сангийн агуулга, бүтцийг сайжруулах талаар судлах<br>• Баяжуулах мэдээний жагсаалтыг гаргах<br>• Ашиглах программ хангамжийг сонгож тогтоох<br>• Логик загварыг тодорхойлох<br>• SQL код боловсруулах<br>• Сайжруулалт хийх программ хангамжийг хөгжүүлэх<br>• Интерфейсийг англи хэл рүү хөрвүүлэх<br>• www.eic.mn -д байршуулах, тогтмол ажиллагааг шалгах, засварлах<br>• Мэдээ, мэдээллээр баяжуулах |
| 3. Төслийн мэдээг тоон ба зурган хэлбэрээр мэдээллийн санд оруулах | • Суурь судалгааны тайлан<br>• Цуглуулсан мэдээ<br>• Биологийн олон янз байдлын тархац, нөөцийн мэдээ, зураг | • Төслөөс хийсэн судалгааны тайлан болон бусад мэдээллийг судлах<br>• Мэдээг цуглуулж мэдээллийн санд оруулах нэгдсэн форматад оруулах<br>• Зурган мэдээнд боловсруулалт хийж мэдээллийн санд оруулахад бэлтгэх<br>• Төслийн мэдээ оруулах программм хангамжид шаардлагатай нэмэлт сайжруулалт хийх<br>• Мэдээллийн санд мэдээ оруулах |

## Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил

Байгаль орчны мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх, хуучин байгаа мэдээллийн сангийн агуулга, бүтцийг сайжруулж программ хангамжид нэмэлт өөрчлөлт оруулах, тусдаа байгаа олон мэдээллийн сангаас мэдээллийг нэгтгэж гаргах боломжийг бүрдүүлэхийн тулд зөвлөх үйлчилгээний ажлыг эхлэхийн өмнө дараах бэлтгэл ажлуудыг хийж эхэлсэн. Үүнд:

- Мэдээллийн сан, мэдээллийн технологийн талаар холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг судалж танилцах;
- Биологийн төрөл зүйл, байгаль орчны талаар хууль эрх зүйн баримт бичигтэй танилцах;
- Биологийн төрөл зүйл, байгаль орчны талаар олон улсын төсөл, хөтөлбөр болон үндэсний хэмжээний баримт бичиг судлах, мэдээлэл цуглуулж танилцах ;
- Мэдээллийн технологийн хөгжилтэй уялдуулан программ хангамж бүтэц, загвар (template) судалж танилцах, ашиглах template сонгох;
- Хэрэглэгчийн шаардлагыг судлан мэдээллийн сангийн агуулга, бүтцийг тодорхойлж дизайныг боловсруулах;
- Байгаль орчны мэдээллийн санг хөгжүүлэхэд ашиглаж байгаа эх код нь нээлттэй (open source) PHP, Geomoose, GeoNetwork, Bootstrap веб програмчлалын сүүлийн хувилбарыг сонгож судлах;
- Байгаль орчны мэдээллийн сангаас хамрах дэд сангуудын агуулга бүрдлийг тодорхойлж сайжруулах шийдлийг гаргах;
- Мэдээллийн санг баяжуулах мэдээний талаар судалгаа хийж шаардлагатай мэдээллийг цуглуулж, санд оруулахад бэлтгэх;
- Ажил үүргийн хуваарь гаргаж багийн гишүүдийн ажлын төлөвлөгөө гаргаж батлуулах;

## Багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь ба гүйцэтгэсэн ажил

| Багийн гишүүний нэр, албан тушаал | Хариуцан гүйцэтгэх ажил | Хийж гүйцэтгэсэн ажил |
|---|---|---|
| Багийн ахлагч, Ерөнхий инженер<br>З.Нарангэрэл | • Гэрээт ажлыг зохион байгуулах, төлөвлөгөө, тайлан бэлтгэх<br>• Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээллийн сангийн загварыг шинэчлэх загвар гаргах, SQL бэлтгэх<br>• Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн сангийн программын front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх<br>• Мэдээллийн сангуудын мэдээ бүрдүүлэх | • Захиалагчтай гэрээ байгуулах баримт бичгийг бэлтгэж гэрээ байгуулсан.<br>• Ажлын нарийвчилсан төлөвлөгөө бэлтгэсэн<br>• Гэрээт ажлын эхлэлийн тайлан бэлтгэж БОАЖЯ болон KfW төсөлд хүргүүлсэн, эхлэлийн санхүүжилтийн нэхэмжлэх өгсөн<br>• Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн сантай холбоотой хууль, эрхзүйн баримт бичигтэй танилцсан.<br>• Мэдээллийн сангийн танилцуулга бэлтгэсэн.<br>• Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн сангийн загварыг гаргаж SQL бэлтгэсэн. |
| Ахлах программист<br>Г.Батхишиг | • “Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан” программ шинээр хөгжүүлэх front-end,back-end<br>• “Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан” программын front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх | • Захиалагчтай гэрээ байгуулах баримт бичгийг бэлтгэж гэрээ байгуулсан.<br>• Ажлын нарийвчилсан төлөвлөгөө бэлтгэхэд оролцон ажилласан.<br>• Багийн гишүүдтэй гүйцэтгэх ажлын талаар ярилцлага хийж ажлын хуваарь гаргасан.<br>• “Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан” программ шинээр хөгжүүлэхэд ашиглах программын судалгаа хийсэн.<br>• Сонгосон программ хангамжийг ашиглан “Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан”-ийн загвар гаргаж программ хангамжийг хөгжүүлж байна.<br>• Багийн гишүүдийн ажлын явцтай танилцаж программ хөгжүүлэх ажилд зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. |

| | | |
|---|---|---|
| Мэдээллийн сангийн захирагч<br>Б.Ундрах | • “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ” front-end, back-end хөгжүүлэх<br>• “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ” программын front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх | • “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ”-ний мэдээллийн санг шинэчлэх программыг хөгжүүлж байна.<br>• “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ” программын front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх ажил хийгдэж байна. |
| Программист<br>З.Цэнд | • Амьтны мэдээллийн сангийн front-end программ шинэчлэх<br>• Амьтны тоон болон газарзүйн мэдээг шалгаж санд оруулах<br>• Амьтны газарзүйн мэдээний давхарга шинээр үүсгэх<br>• Амьтны сангийн программын front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх | • Мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх талаар судалгаа хийж программ, загварыг сонгосон.<br>• Амьтны мэдээллийн сангийн front-end программ шинэчлэх ажлыг гүйцэтгэж байна.<br>• Амьтны сангийн программын front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх |
| Программист<br>М.Оюунболор | • Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн front-end,back-end хөгжүүлнэ.<br>• Байгаль орчинд учруулсан хохирлын, нөхөн төлбөрийн тоон мэдээг шалгаж санд оруулах.<br>• Байгаль орчинд учруулсан хохирлын, нөхөн төлбөрийн сангийн программын front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх | • Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээллийн сантай холбогдох хууль эрхзүйн баримт бичигтэй танилцсан.<br>• Мэдээллийн сангийн загвар гаргахад шаардлагатай танилцуулга бэлтгэсэн.<br>• Мэдээллийн сангийн загварыг сонгож программ хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна.<br>• Мэдээллийн сангийн front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх ажил хийгдэж байна. |
| Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн<br>Н.Гандолжин | • Ургамлын мэдээллийн сангийн front-end программ шинэчлэх<br>• Ургамлын тоон мэдээг шалгаж санд оруулах<br>• Ургамлын газарзүйн мэдээний давхарга шинээр үүсгэх<br>• Ургамлын сангийн программын front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх | • Ургамлын мэдээллийн сангийн front-end программ шинэчлэх ажил хийгдэж байна.<br>• Ургамлын сангийн программын front-end интерфейсийг англи хэлрүү хөрвүүлэх ажил хийгдэж байна. |

| | | |
|---|---|---|
| Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн Б.Вандандорж | • “Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан” мэдээ оруулах<br>• Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээг бэлтгэх<br>• Амьтны мэдээллийн сангийн газарзүйн мэдээг бэлтгэх<br>• “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ” мэдээ оруулах | • Хамрагдаж байгаа мэдээллийн сангуудад оруулах мэдээний талаар судалгаа хийж мэдээ оруулах хүснэгтүүд бэлтгэсэн.<br>• “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ”-ний мэдээллийн санд оруулсан мэдээг хянаж шинэчлэн хөгжүүлсэн мэдээллийн санд оруулахад бэлтгэж байна.<br>• Мэдээллийн сангуудад оруулах газарзүйн мэдээг бэлтгэж байна. |

## Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан шинээр хөгжүүлэх

Байгаль орчны мэдээллийн сан дах тусдаа салангид байгаа олон төрлийн мэдээллийн дэд сангуудыг уялдуулан холбож газарзүйн болон тоон мэдээллийг нэгдсэн нэг порталаар нэгтгэн харуулах боломжийг бүрдүүлж “Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан” - г шинээр үүсгэв. Шинээр хөгжүүлсэн мэдээллийн санд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ https://eic.mn/eia/, Байгаль орчны аудит https://eic.mn/audit/, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө https://eic.mn/envmng/, Эвдэрсэн газар https://eic.mn/dlid/, Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагаа https://eic.mn/cadastre/ зэрэг мэдээллийн дэд сангуудыг хамруулав. Нэгдсэн портал хөгжүүлэхийн тулд хамруулж байгаа мэдээллийн сангуудаас өгөгдөл мэдээллийг ямар ямар үзүүлэлтээр нэгтгэх талаар дүн шинжилгээ хийж загвараа гарган программ хөгжүүлэлт хийсэн.




Мэдээллийн сангийн бүтэц, агуулгад сайжруулалт хийж
“Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан”-д хамруулсан дэд сангууд




“Байгаль орчны нөлөөллийн нэгдсэн сан”-гийн Нүүр хуудас

Нэгдсэн сангийн Нүүр хуудас дах үндсэн цэсний Төслийн мэдээлэлд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан” дах Батлагдсан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн (6990) мэдээг Уул уурхайн төсөл (1545), ХАА, үйлдвэрлэлийн төсөл (1714), Дэд бүтцийн хөгжлийн төсөл (960), Үйлчилгээний төсөл (2771) гэсэн Үнэлгээний чиглэлээр ангилан мэдээ оруулсан огноогоор эрэмбэлэн харуулна.




Төслийн мэдээг Төсөл хэрэгжих аймгаар шүүж харах боломжтой бөгөөд тухайн аймагт хэрэгжих нийт төслийг нэгтгэн харуулна. Мөн тухай жилд батлагдсан төслийн тоог гаргасан.




Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний мэдээг төслийн Дэлгэрэнгүй харах хэсэгт харуулна. Үнэлгээний тайланд хавсаргасан хавсралт мэдээ (*pdf) файлыг тухай бүрд нь гүйлгэж харах, хэвлэх боломжтой.




Нүүр хуудасны хэсэгт Нарийвчилсан үнэлгээний тайлангийн тоо, Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо, Эвдэрсэн газрын тоо, Гол, мөрний урсац бүрэлдэх эх газрын талбайн мэдээг холбогдох 4 мэдээллийн сангаас нэгтгэн харуулах ба эвдэрсэн газрын тоог аймгийн хэмжээгээр харуулах боломжийг бүрдүүлж программчилсан.



Байгалийн ургамал, Амьтны мэдээллийн сангаас Улаан ном, Улаан дансанд бүртгэгдсэн амьтан, ургамлын мэдээг нэгдсэн байдлаар харуулж байна.

Статистик тайлангийн хэсэгт Байгаль орчны статистик мэдээллийн сангийн БОХ-4.1 маягтаар жил бүр цуглуулдаг Биологийн олон янз байдлын жилийн мэдээг хүснэгтээр гаргана. Мэдээнд Амьтан, ургамлын аймгийн зүйлийн нийт тоог ховордлын зэргээр ангилан харуулна.







Газарзүйн мэдээнд Засаг захиргааны хил, ТХГН, Хамгаалалтын бүсүүд, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, Эвдэрсэн газрын байршил, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлангийн давхаргуудыг оруулсан.



Мэдээллийн сангийн олон нийтэд зориулсан хэсэг болон Газарзүйн мэдээний хэсгийг англи хэл рүү хөрвүүлсэн. Газарзүйн мэдээг GeoMoose 3.8.0 -аас 3.10.1 хувилбар луу шилжүүлж бүтэц, загварыг бүрэн шинэчилж программ хөгжүүлэлт хийсэн.




Мэдээллийн санд нэмэлт хөгжүүлэлт хийх, программ хангамжийг сайжруулж дээд хувилбарт шилжүүлэх, олон мэдээллийн сангуудаас мэдээг нэгтгэн мэдээллийг нэг цонхоор тайлагнах боломжийг бүрдүүлсэн нь чухал ач холбогдолтой ажил болсон.

## Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх

Мэдээллийн сан нь Батлагдсан нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт болон Батлагдсан нарийвчилсэн үнэлгээний тайлан, Газарзүйн мэдээллээс бүрдэнэ. Үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага мэдээгээ оруулдаг бөгөөд нарийвчилсан үнэлгээний 6990 мэдээ агуулагдаж байна. Мэдээллийн санг 2012 онд хөгжүүлсэн тул мэдээллийн санг бүтэц загвар болон программ хөгжүүлэлтийн хувьд бүрэн шинэчлэх шаардлагатай болсон. Мэдээллийн санд үнэлгээний эрх бүхий 191 мэргэжлийн байгууллага хандаж Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний мэдээ оруулдаг хандалт ихтэй мэдээллийн сан тул программ хангамжийг шинэчлэх нь чухал байв.









Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санг программ хөгжүүлэлтийн Bootstrap v3.3.5 хувилбараар хөгжүүлсэн байв. Мэдээллийн сангаас хүснэгтээр мэдээ гаргах функцгүй бөгөөд газарзүйн мэдээ оруулахад хэрэглэгчээс олон үйлдэл шаарддаг байв.

Мэдээллийн сангийн олон нийтийн харах хэсэг болон мэдээ оруулах хэсгийн хэлбэржүүлэлтийн Framework болох Bootstrap v3.3.5 хувилбарыг Bootstrap v4.3.1 хувилбарт шилжүүлсэн. Уг шинэчлэлтийн хүрээнд олон нийтийн хэсэг нүүр хуудас болон мэдээ харуулах хэсгийн хэрэглэгчийн интерфейс (template) бүрэн солигдсон бөгөөд олон нийтэд нээлттэй харуулах 5 хүснэгтийн (Батлагдсан БОННҮ-ний тайлан, Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, Хууль эрхзүй, Мэдээ мэдээлэл) загварыг шинэчилж программчилсан.



Мөн мэдээний хүснэгтүүдэд “хуулах, excel, pdf файлд мэдээг гаргах, хэвлэх” функцуудийг нэмсэн. Олон нийтэд зориулсан бүх хэсгийг англи (language.php_en), монгол хэл (language.php_mn) дээр орчуулсан.







Мэдээллийн сангийн Газарзүйн мэдээг дүрслэх Framework-ийг GeoMoose v3.8.0 -аас v3.10.1 хувилбар луу шилжүүлсэн. Мөн (.*map, *.xml, .*html, *.js) өргөтгөл бүхий файлуудыг англи, монгол хэл дээр хөрвүүлсэн.



Газарзүйн мэдээнд Нарийвчилсан үнэлгээ хийсэн газрын байршлыг үнэлгээ хийсэн оноор, салбараар харах давхарга үүсгэсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, усны сав газар, ойн тархалт, ТХГН болон суурь зургийг давхарга үүсгэн харах боломжтой.




Мэдээллийн сангийн мэдээ оруулах хэсгийн шинэчлэлтийн хүрээнд удирдах хуудас болон мэдээний хүснэгтүүдийн интерфейс (template) бүрэн солигдсон бөгөөд 13 хүснэгтийн загварыг шинэчилж кодчилон программыг хөгжүүлсэн. Мөн тухайн хүснэгтүүдэд “хуулах, excel, pdf файлд мэдээг гаргах, хэвлэх” функцуудийг нэмсэн. Тухайн хүснэгтүүдийн мэдээг тодорхой утгаар хайлт хийн excel (*xlsx) болон shape (*shp) файлаар гаргах функцуудийг нэмсэн.

Мэдээллийн сангийн лавлах 6 хүснэгтэд англи нэршил оруулах багана нэмж англи нэршлүүдийг мэдээллийн санд нэмж оруулсан. “Мэргэжлийн байгууллагын эрхийн бүртгэлд; Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага; Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх нь дууссан бүхий мэргэжлийн байгууллага; хүснэгтүүдэд регистрийн дугаараар хайх хайлтыг нэмсэн. Мөн батлагдсан БОННУ-ний тайлангийн хүснэгтээс тайлангийн

кадастрын зураг болон тайлангийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээний мэдээллийг шууд оруулах хэсгийг шинээр нэмсэн.

Мэдээллийн санд тусгай эрх бүхий хэрэглэгч Нэвтрэх нэр, Нууц үгээр нэвтрэх боловч Хэрэглэгчийн төрөл нь Мэдээ оруулах, Админ болон Бүртгэлтэй хэрэглэгч гэсэн ялгаатай байна. Мэдээ оруулах хэрэглэгч мэдээ оруулах, өөрийн оруулсан мэдээг засварлах эрхтэй бөгөөд бусдын оруулсан мэдээг зөвхөн харах эрхтэй байна. Админ хэрэглэгч мэдээллийн санд мэдээ оруулах, засварлах, устгах үйлдлийг хийнэ. Бүртгэлтэй хэрэглэгч зөвхөн оруулсан мэдээг харах эрхтэй байна.



## Мэдээллийн санг  шинэчлэн хөгжүүлж мэдээллээр баяжуулах

Байгаль орчны мэдээллийн санд биологийн олон янз байдлын талаарх мэдээллийг Байгалийн ургамал https://eic.mn/flora/, Амьтан https://eic.mn/fauna/, Байгаль орчны статистик мэдээллийн БОХ-4.1 маягтаар гаргадаг Биологийн олон янз байдлын жилийн мэдээ  https://eic.mn/statistic  харуулна.

